



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2023/88/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Өлгий хот
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: Х.Манаргүл
Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5.1 Завсрын аудитын талаар.....	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	Error! Bookmark not defined.
5.1 Төлбөрийн акт	Error! Bookmark not defined.
5.2 Албан шаардлага	Error! Bookmark not defined.
5.3 Зөвлөмж	Error! Bookmark not defined.
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ТОЛБО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
М.ХУРМАНГАЗЫ ТАНАА

᠒᠐᠒3.0᠗.24 № 213
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2022 оны санхүүгийн тайлантай холбоотой онцлог асуудал байхгүй байна.

Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>56,933,546.67</u>	<u>60,953,246.67</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	18,018,900.00	100.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	18,018,900.00	100.00
3121	Төгрөг	18,018,900.00	100.00
31211	Төрийн сангийн харилцах	18,018,900.00	100.00
33	АВЛАГА	8,219,018.67	4,557,518.67
335	Бусад авлага	8,219,018.67	4,557,518.67
3352	Хувь хүмүүсээс авах авлага	8,219,018.67	4,557,518.67
35	БАРАА МАТЕРИАЛ	30,695,628.00	56,395,628.00
354	Хангамжийн материал	30,695,628.00	56,395,628.00
35420	Аж ахуйн материал	30,695,628.00	30,895,628.00
35470	Бусад хангамжийн материал		25,500,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,205,251,683.62</u>	<u>1,218,176,895.50</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,205,251,683.62	1,218,176,895.50
392	Биет хөрөнгө	1,188,571,683.62	1,201,514,895.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	958,071,931.00	958,071,931.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(323,274,377.94)	(360,664,049.07)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	164,879,994.00	148,629,994.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(154,933,148.92)	(140,408,747.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	585,003,307.00	520,721,934.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(348,976,927.09)	(272,903,352.30)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,348,468.00	18,372,872.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,172,384.55)	(12,156,857.26)
39209	Зам, гүүрийн байгууламж	-	39,500,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	(329,166.67)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	5,234,600.00	5,234,600.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	415,565,880.00	451,134,580.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(121,175,657.88)	(153,688,843.20)
393	Биет бус хөрөнгө	16,680,000.00	16,662,000.00
39301	Програм хангамж	1,486,400.00	1,486,400.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,468,400.00)	(1,486,400.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,662,000.00	16,662,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,262,185,230.29</u>	<u>1,279,130,142.17</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,262,185,230.29</u>	<u>1,279,130,142.17</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,262,185,230.29	1,279,130,142.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	490,884,758.00	490,884,758.00
51101	Өмч: - төрийн	490,884,758.00	490,884,758.00
512	Хуримтлагдсан үр дүн	341,214,682.88	358,159,594.76
51210	Өмнөх үеийн үр дүн	341,214,682.88	341,214,682.88
51220	Тайлант үеийн үр дүн	-	16,944,911.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	430,085,789.41	430,085,789.41

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,262,185,230.29</u>	<u>1,279,130,142.17</u>
---	--	--------------------------------	--------------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	458,038,812.00	605,772,285.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	39,500,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	39,500,000.00
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	-	39,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	458,038,812.00	566,272,285.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	426,800,600.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	362,219,400.00	-
131005	Хөрөнгийн санхүүжилт	64,581,200.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,238,212.00	12,693,575.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,755,637.00	2,488,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,482,575.00	10,205,175.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	553,578,710.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	406,146,610.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	-	19,500,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	127,932,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	529,202,044.85	581,477,373.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	529,202,044.85	581,477,373.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	504,906,160.85	514,185,986.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,692,028.00	261,969,659.00
210101	Үндсэн цалин	157,109,952.00	187,855,577.00
210102	Нэмэгдэл	65,983,790.00	45,854,172.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,598,286.00	28,259,910.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,112,819.00	32,786,939.00
210201	Тэтгэврийн даатгал	22,157,714.00	23,468,139.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,851,052.00	2,329,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,901,473.00	1,863,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	474,394.00	466,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,728,186.00	4,659,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,472,118.00	20,683,700.00
210301	Гэрэл, цахилгаан	2,038,418.00	1,865,000.00
210302	Түлш, халаалт	17,433,700.00	18,818,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,430,825.00	23,774,040.00
210401	Бичиг хэрэг	2,191,500.00	2,121,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,381,205.00	18,506,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,420,100.00	3,059,040.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	87,900.00
210408	Бараа материал акталсны зардал	40,438,020.00	-

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	457,000.00	457,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457,000.00	457,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,472,800.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	3,472,800.00	1,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,318,125.00	2,666,000.00
210702	Дотоод албан томилолт	3,318,125.00	2,666,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,362,060.00	1,699,360.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	132,000.00	529,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	352,200.00	362,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193,844.00	150,660.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	23,816.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	439,100.00	379,700.00
210807	Газрын төлбөр	45,600.00	37,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	67,200.00	75,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	149,588,385.85	169,049,288.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,610,495.33	49,911,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	440,650.00	400,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	106,537,240.52	118,737,888.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,295,884.00	67,291,387.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	30,418,400.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	30,418,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	31,753,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	27,733,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	4,020,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	24,295,884.00	5,119,787.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,295,884.00	5,119,787.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(71,163,232.85)	24,294,911.88
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	140,000.04	7,350,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	140,000.04	7,350,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(140,000.04)	(7,350,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(71,303,232.89)	16,944,911.88

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>393,457,612.00</u>	<u>449,259,185.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	393,457,612.00	449,259,185.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,238,212.00	12,693,575.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,755,637.00	2,488,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,482,575.00	10,205,175.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	362,219,400.00	436,565,610.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	362,219,400.00	406,146,610.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		30,419,000.00

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	402,432,787.33	464,777,985.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	402,432,787.33	464,777,985.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	378,136,903.33	397,486,598.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,692,028.00	261,969,659.00
210101	Үндсэн цалин	157,109,952.00	187,855,577.00
210102	Нэмэгдэл	65,983,790.00	45,854,172.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,598,286.00	28,259,910.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,127,322.00	32,786,939.00
210201	Тэтгэврийн даатгал	20,599,975.00	23,468,139.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,423,294.00	2,329,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,901,473.00	1,863,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	474,394.00	466,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,728,186.00	4,659,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,472,118.00	20,683,700.00
210301	Гэрэл, цахилгаан	2,038,418.00	1,865,000.00
210302	Түлш, халаалт	17,433,700.00	18,818,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,112,805.00	23,774,040.00
210401	Бичиг хэрэг	2,311,500.00	2,121,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,381,205.00	18,506,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,420,100.00	3,059,040.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		87,900.00
2105	Нормативт зардал	457,000.00	457,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457,000.00	457,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,072,800.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	3,072,800.00	1,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,318,125.00	2,666,000.00
210702	Дотоод албан томилолт	3,318,125.00	2,666,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,482,060.00	1,699,360.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	252,000.00	529,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	352,200.00	362,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193,844.00	150,660.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	23,816.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	439,100.00	379,700.00
210807	Газрын төлбөр	45,600.00	37,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	67,200.00	75,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,402,645.33	52,349,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,961,995.33	51,949,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	440,650.00	400,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,295,884.00	67,291,387.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	30,418,400.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		30,418,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	31,753,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		27,733,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		4,020,000.00

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	24,295,884.00	5,119,787.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,295,884.00	5,119,787.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(8,975,175.33)</u>	<u>(15,518,800.00)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	2,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2,500,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	2,500,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		2,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(2,500,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(8,975,175.33)	(18,018,800.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26,994,075.33	18,018,900.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,018,900.00	100.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2021оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	490,884,758.00	430,085,789.41	341,214,682.88	1,262,185,230.29
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	490,884,758.00	430,085,789.41	341,214,682.88	1,262,185,230.29
D08	Тайлант үеийн үр дүн			16,944,911.88	16,944,911.88
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	490,884,758.00	430,085,789.41	358,159,594.76	1,279,130,142.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	466,446,500.00	454,169,898.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	466,446,500.00	454,169,898.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	403,452,500.00	391,998,198.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	268,210,300.00	261,969,659.00
210101	Үндсэн цалин	188,690,000.00	187,855,577.00
210102	Нэмэгдэл	47,926,900.00	45,854,172.00
210105	Гэрээт ажлын хөлс	31,593,400.00	28,259,910.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,526,200.00	32,786,939.00
210201	Тэтгэврийн даатгал	24,207,400.00	23,468,139.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,329,700.00	2,329,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,863,700.00	1,863,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	466,000.00	466,000.00

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	4,659,400.00	4,659,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,683,700.00	20,683,700.00
210301	Гэрэл, цахилгаан	1,865,000.00	1,865,000.00
210302	Түлш, халаалт	18,818,700.00	18,818,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,266,200.00	22,255,640.00
210401	Бичиг хэрэг	2,121,800.00	2,121,000.00
210402	Тээвэр, шатахуун	16,987,700.00	16,987,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,068,700.00	3,059,040.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	88,000.00	87,900.00
2105	Нормативт зардал	457,000.00	457,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	457,000.00	457,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,100,000.00	1,100,000.00
210604	Урсгал засвар	1,100,000.00	1,100,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,260,600.00	2,236,000.00
210702	Дотоод албан томилолт	2,260,600.00	2,236,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,729,600.00	1,699,360.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	529,200.00	529,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	362,200.00	362,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	90,300.00	90,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180,900.00	150,660.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	75,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	379,700.00	379,700.00
210807	Газрын төлбөр	37,300.00	37,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	75,000.00	75,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,218,900.00	48,809,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,818,900.00	48,409,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	400,000.00	400,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	62,994,000.00	62,171,700.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	30,419,000.00	30,418,400.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	30,419,000.00	30,418,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,575,000.00	31,753,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,733,300.00	27,733,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,841,700.00	4,020,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	466,446,500.00	436,150,998.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	466,446,500.00	436,150,998.00
132001	Орон нутгийн төсвөөс	436,027,500.00	405,731,998.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	30,419,000.00	30,419,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	18,018,900.00	18,018,900.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	100.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00
620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	4	4
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.0	25.0

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.0	9.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.0	8.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8.0	8.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,548,400.00	7,988,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,548,400.00	7,988,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,548,400.00	7,988,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,518,400.00	1,518,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,518,400.00	1,518,400.00
2107	Томилолт, зочны зардал	430,000.00	430,000.00
210702	Дотоод албан томилолт	430,000.00	430,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,600,000.00	6,040,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,600,000.00	6,040,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,693,575.00	7,988,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,693,575.00	7,988,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,693,575.00	7,988,400.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Толбо сумын Засаг даргын тамгын газрын зорилго нь: Удирдлага болон нөөцийн үр ашгийг дээшлүүлж төрийн үйлчилгээний шуурхай байдал чанар хүртээмжийг сайжруулах

Дээрх зорилгынхоо хүрээнд дараах зорилтыг тавьж ажилласан байна.Үүнд:

- Төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжуудыг ажилдаа мөрдлөг болгож, авлига, ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх
- Үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг дагаж мөрдөн, дотоод ажлыг сайжруулах
- Ажлын цагийн ашиглалтыг сайжруулж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний ажлын хөнгөн шуурхай байдлыг хангах
- Байгууллагын санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд ил тод байдлыг хангаж ажиллах

Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөгөө зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, Засаг даргын бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ИТХ, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны

байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар

Толбо сумын Засаг даргын тамгын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Толбо сумын Засаг даргын тамгын газар нь НББ-ийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөж ажилласан боловч даргын тушаалаар баталгаажуулаагүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 38.9 сая төгрөгөөр буюу 3.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	18,018.9	0.1	(18,018.8)
Авлага	8,219.0	4,557.5	(3,661.5)

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	30,695.6	78,395.6	47,700.0
Үндсэн хөрөнгө	1,205,251.7	1,218,176.9	12,925.2
Нийт хөрөнгө	1,262,185.2	1,301,130.1	38,944.9
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,262,185.2	1,301,130.1	38,944.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,262,185.2	1,301,130.1	38,944.9

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Мөнгөн хөрөнгийн данс оны эхэнд 18.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба оны эцэст 0.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Авлагын дансны үлдэгдэл 4.5 мянган төгрөг болж 3.6 сая төгрөгөөр буурсан нь иргэдэд тараасан өвсний үнийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 78.4 сая төгрөг болж 47.7 сая төгрөгөөр өссөн. Төсвийн хөрөнгөөр 32.6 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, сумын ОНХСангийн хөрөнгөөр 20.0 сая, нэмэлт данснаас 22.0 сая бүгд 42.0 сая өвс тэжээлийг хүлээн авчавч данс бүртгэлд тусган, 26.9 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1218.2 сая төгрөг болж 12.9 сая төгрөгөөр өссөн нь 2.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, аймаг, сумын ОНХСан бүгд 136.5 сая төгрөгийн машин, тоног төхөөрөмж, зам гүүр, бусад үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Тайлант онд 38.9 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 38.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 453.6 сая, нийт зарлагыг 453.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа үйлчилгээний бусад зардал 53.2 сая, урсгал шилжүүлэг 30.4 сая төгрөгөөр тус тус өссөн ба цалин, НДШимтгэлийн зардал 34.5 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 10.3 сая, хангамж бараа материалын зардлыг 14.5 сая, норматив зардал 0.7 сая, эд хогшил урсгал зардал 4.7 сая, томилолт, зочны зардал 2.9 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 3.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, нийт зардлыг 466.4 сая төгрөгөөр баталсан байна.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны анх батлагдсан төсөв 420.5 сая төгрөг ба тодотгосон төсөв 466.4 сая төгрөг байна. Тодотгосон төсөв нь анх баталсанаас 45.9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага гэсэн 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 436.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 30.4 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас бүгд 466.4 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 406.1 сая, орон нутгийн хөгжлийн сангаас 30.4 сая бүгд 436.5 сая төгрөгийг санхүүжилт олгож гүйцэтгэл 93.6 хувьтай байгаа нь 6.4 хувь буюу 29.9 сая төгрөгөөр санхүүжилт дутуу авсантай холбоотой байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 97.4 хувь 454.2 сая төгрөг байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардал бүрээр задалж харуулахад цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардал 262.0 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 32.8 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 20.7 сая, хангамж, бараа материалын зардал 22.3 сая, нормативт зардал 0.5 сая, эд хогшил, урсгал засварын зардал 1.1 сая, томилолт, зочны зардал 2.2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 1.7 сая, бусад бараа үйлчилгээний зардал 48.8 сая бүгд 454.2 сая төгрөг байна.

Нийт төсвийн зарлагын 57.7 хувийг цалингийн зардал, 7.2 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 4.6 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 4.9 хувийг хангамж, бараа материалын зардал, 17.7 хувийг урсгал шилжүүлэг, 10.7 хувийг бараа үйлчилгээний бусад зардал эзэлж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	302,533.0	295,763.8	(6,769.2)	98%
2	Туслах үйл ажиллагааны зардал	76,019.5	75,743.4	(276.1)	100%
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	4,841.7	4,020.0	(821.7)	83%
4	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөг	27,733.3	27,733.2	(0.1)	100%
5	Орон нутгийн нөөц хөрөнгө	19,900.0	15,491.0	(4,409.0)	78%
6	Улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	-	100%
7	ОНХС - Итгэлцүүрээр олгох	30,419.0	30,419.0	-	100%
	Дүн	466,446.5	454,170.4	(12,276.1)	97%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд мал тооллогын зардалд 2.2 сая, сумын ИТХ-аас 0.3 сая төгрөг, өвс тэжээл худалдсаны орлогоос 10.2 сая төгрөг, бүгд 12.7 сая төгрөгийн орлого оруулан 8.0 сая төгрөгийг өвс тэжээл худалдан авах болон бусад зардалд зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл болох 4.7 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Толбо сумын Засаг даргын тамгын газар нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий ймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 3/24 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 529.2 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 10.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар 29 арга хэмжээний хэрэгжилтийг шалгаж үзэхэд алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Толбо сумын Засаг даргын тамгын газар нь 2022 онд нийт 436.5 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 81.3% байна. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 15 шийдвэрийн 32.9 сая төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 18.0 сая төгрөгийн акт тогтоож, 1 зөвлөмж өгөгдсөнийг хугацаанд биелэлтийг албан бичгээр ирүүлсэн байна.

4 Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
	/мянган төгрөгөөр/				
Акт	1	18018.9	1	18018.9	100%
Албан шаардлага					
Зөвлөмж	1	17900.0	1	17900.0	100%
Нийт дүн	2	35918.9	2	35918.9	100%

5.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй.Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж орон нутгийн төсвөөс болон ОНХСангаас авсан санхүүжилтийн зарцуулалтын тооцоог бүрэн шалгах боломжгүй, зөвхөн санхүүгийн тайлан гаргалтыг шалгаж баталгаажууллаа.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 24.5 сая төгрөгийн алдаа илэрч аудитын явцад залруулга хийсэн.Үүнд:

Мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө худалдан авсан 2.5 сая төгрөгийн гүйлгээг бараа үйлчилгээний бусад зардлаар тайлагнасныг биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлаар залруулав.

Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 20.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг барилга байгууламж дансад бүртгэсэнийг залруулав.

Аудитын дүнгээр 152.2 сая төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг дахин давтан гаргахгүй байх талаар 2 зөвлөмж өгөв.

5.1 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

5.2 Албан шаардлага

Албан шаардлага байхгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэхтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Албан томилолт, мал эмнэлгийн арга хэмжээ, интентийн үнэ зэрэг зардлуудын нийт 119.3 сая төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

1.2 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх заавар аргачлалын хэрэгжилтийг хангаж ажиллах.

2. Шилэн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан 32.9 сая төгрөгийн 15 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй, мэдээлсэн байдлын хэрэгжилт 81.3 хувьтай байна.

2.1 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг мөрдөж мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс		Зөвлөмж
				Залруулсан	Залруулаагүй	

Толбо сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Залруулсан алдаа	1	24500.0			1	24500.0	1	24500.0				
Дүн	1	24500.0			1	24500.0	1	24500.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж	1	119371.6					1	119371.6				
Дүн	1	119371.6					1	119371.6				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 15 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй	1	32925.1					1	32925.1
Дүн	1	32925.1					1	32925.1
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	32925.1					1	32925.1